

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ренчин	Дугаар	L295
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цагаан-Үүр сум
Төрсөн газар	Цагаан-Үүр сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дархинтын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЦҮ 049
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Дархинтын хүрээ

Мөнхбат: Ингээд Ренчин гуайгаас дараах хэдэн асуултыг асуух гэсэн юм аа. За тэгэхээр Дархинтынг хүрээ тухайн үедээ хэдэн дугантай, хэдэн ламтай шашны зан үйлийн одоо ямар ямар үйл ажиллагаа явуулдаг байсан юм бэ, энэ талаар та одоо үзсэн харсан, сонссон зүйлээсээ одоо хуваалцана уу?

Ренчин: Би одоо ярих уу?

Мөнхбат: Аа ярина, та.

Ренчин: Би одоо арван гурван настай л байсан шиг байна. Дархинтын хүрээг одоо лам нар нь баригдаж, татан буугдах үед тэнд би өөрөө нутаглаж байсан. Тэгээд хүрээ хийд, бүх доторх юмыг нь бол хураагаад аваад явчихсан. Тэгээд нэг хөндий дуган байшин үлдсэн. Тэрүүнийг нь бидэнд, ном судрыг нь бол үрж, түйвэргээд л, мод хашааг нь яахав түлээнд хэрэглээд л тэгээд л байсан үе юм байнаа. Тэр бол, тэр хүрээ бол яахав дээ гучаас дөчин лам суурин байсан. За хичнээн ч цам гарч байсан юм, цам майдар гарч л байсан. Тийм байсан юм. Тэгээд яахав бага байхад мэдэхийгээ л ярихад ийм байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Гурван дуганы тууриас гадна бас нэг жижиг одоо тийм таван метрийн урттай, гурав дөрвөн метрийн өргөнтэй болов уу гэмээр чулуун ийм бас нэг барилгуудын туурь байгаа юм, одоо тойроод. Нэг эгнээнд тав байж байх жишээтэй. Чулуунууд нь яг ингээд байж байгаа юм.Тэгэхээр тэр юуны зориулалттай тийм дуганууд байсан юм бол? Одоо жишээ нь энэ дээр ингээд гурван дуганы том сууриуд, тод сууриуд байж байгаа юм.Тэгээд араар нь ийм одоо чулуун сууриуд байгаа юм.

Ренчин: Үгүй, одоо тэр юуны суурь...

Мөнхбат: Энэ одоо лам нарын байрнууд байсан юм болов уу?

Ренчин: Байрны сууриуд байх аа , тэр их хавтгай газар байгаа.Тэгээд чулуугаар яагаад байлгүй. Тэр өөр тэр жижигхэн дуганархуу юм ер нь байгаагүй дээ.Тэр урд талд нь бол нэг жижигхэн асархуу хэлбэртэй дуган байсан.Тэр дотор бол нэг том хүрд л байсан гэж...

Мөнхбат: За тэрний чинь суурь бол энд байгаа юм. Яг энэ голын цогчин дуган болов уу гэмээр энэ дуганаас гучаад метр бололтой юм бололтой юм.

Ренчин: Тийм тийм.

Мөнхбат: Тав гурвын харьцаатай болов уу гэмээр, энэнийх бол их тод үлдсэн байгаа юм, суурь нь.Дөрвөн талынх нь юу дөрвүүлээ байж байгаа юм.Энд бол хүрд л байсан болов уу?

Ренчин: Харин хүрд байсан юм.Тэрнийг чинь би эргүүлж мөргөж явж байсан.

Мөнхбат: Би бас энийг нэг тэгж бодож байсан юм, энэ бол суварганы суурь байсан эсвэл...

Ренчин: Шон нь шатаад суурь нь үлдчихсэн байсан юм аа.Тэр мэдэгдэж байгаа байна.

Мөнхбат: Тэгэхээр энэ Дархинтын хүрээ бол энэ Даяндээрхийн хүрээтэй бас их холбоотой байсан гэж та хэлж байна.

Ренчин: Холбоотой байсан, тийм яг. Цам майдар нь солилцож гарч байсан. Яахав энэ хүрээнээс очиж, тэр Дээрхийн хүрээн дээр очиж цамаа бүрдүлж байсан юм байгаа биз.

Мөнхбат: Тэгэхээр энэ Даяндээрхийн хүрээний одоо дараа мэдээж байгуулагдсан байгаа гэж үзэж байна, тийм ээ?

Ренчин: Аа тэр дараа байх.

Мөнхбат: Дараа байгуулагдсан байх л гэж миний хувьд ингэж бодож байна л даа.За яагаад гэвэл арай одоо жижигхэн , тэр Даяндээрхийн хүрээнээс.Одоо лам нарын тоо нь цөөхөн ийм байсан юм шиг байгаа юм, тийм ээ.Тэгэхээр энэ бол дараа нь байгуулагдсан болов уу гэж бодож байна, Даяндээрхийн хүрээнээс дараа л байгуулагдсан болов уу гэж.

Ренчин: Тийм л байх.цөөхөн

Мөнхбат: Тэгэхээр гучин найман онд хаагдсан гэж та үзэж байна уу, тийм ээ?

Ренчин: Гучин найман онд л хаагдсан.Лам нарыг нь бариад явсан.

Мөнхбат: Тэгээд дараа нь бол лам нарыг нь бариад явсны дараа бол хүрээ эзгүйрсэн?

Ренчин: Хүрээ эзгүй үлдсэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Аа сүм дуган нь бол бариатайгаа байсан ?

Ренчин: Бариатайгаа байсан.

Мөнхбат: Тэрнийг одоо хэдий үед галдан шатаасан байх нь уу, нураагаад аваад явчихсан байх нь уу, яасан бол тэр одоо үлдсэн хүрээ хийдийг?

Ренчин: Харин хавийн айлууд нураагаад түлчихсэн.

Мөнхбат: Нураагаад л түлчихсэн?

Ренчин: Тэгсэн. Аваад явсан юм ер байхгүй.

Мөнхбат: Тэгээд л байшин бариад л?

Ренчин: Тэгээд л анхан дуганыг нь түлж, буулгаж түлээд л яс мод нь үлдсэн л байсан. Тэгээд сүүлдээ босоо холтостойгоо тарган хашаа гэдэг, урьд нь хашаа босоо мод аваачаад хашаагаа барьдаг байсан ш дээ.Тэгээд тэрийг нь түлээд л дуусгасан.

Мөнхбат: Тэгээд л дуусгасан?

Ренчин: Тийм.

Мөнхбат: Одоо ер нь энэ нутагт багадаа Дархинтын хүрээнд шавилж байсан, сууж байсан, тийм хүн ер нь үгүй болж тийм ээ?

Ренчин: Байхгүй л болоод байна.

Мөнхбат: За таньд баярлалаа.Ингээд таны өгсөн энэ мэдээлэл манай судалгааны ажилд бас зохих хэмжээний хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа. За таньд баярлалаа.